

- Зээл олгогч мөн таны өрийг өөр компанид зарж болно, энэ тухай заавал бичгээр мэдэгдэх ёстой. Шинэ компани танаас хуучин байгууллагын оронд өрийг нэхэмжилж болно.
- Зээл олгогч таныг шүүхэд өгсөн өргөдлийг таньгүйгээр хэлэлцээд танд өрийг төлөх захирамж (platební rozkaz) явуулдаг. Төлбөрийн захирамж баталгаат шуудангаар ирэх ёстой, хэрвээ танд ирээгүй бол шүүх захирамжаа хүчингүйд тооцож дахин хурлын цаг тогтоож таныг дууддаг. Төлбөрийн захирамжийг зөвшөөрөхгүй байгаагаа (odpor) илэрхийлж болох ба (эсэргүүцэлээ илэрхийлэх хугацаа захирамжид бичигдсэн богино хугацаа байдаг) шүүх дахин захирамж гаргадаг. Энэ үйл явц таны хөрөнгийг хураах шийдвэрээр (rozsudek) төгсөж болох юм. Шийдвэрийн эсрэг давж заалдаж (odvolání) болно.

Анхаар! Шүүхээс таны хөрөнгийг хураах шийдвэр таны гарт очоогүй эсвэл та хүлээж авахыг хүсээгүй байсан ч шийдвэр хуулийн дагуу хүчин төгөлдөр байдаг!

- Нотолгоо нь үнэн биш, та өр төлөөсөө төлөөд явж байгаагаа нотолж чадах юм бол төлбөрийн захирамжийн эсрэг гаргах эсэргүүцэл эсвэл таны хөрөнгийг хураах шийдвэрийг давж заалдах үйл явцад танд ялах боломж байдаг. Танаас хэн нэгэн хууль бусаар өр төлөөс нэхэмжилж буй тохиолдолд энэ давж заалдах үе шат таны хамгийн сүүлчийн боломж юм. Хэрвээ танд нотолгоо баримт байхгүй бол давж заалдах явц багагүй цаг хугацаа шаардах ба ялгаагүй та өрөө төлөх үүрэгтэйгээс гадна үүн дээрээс дараагийн шийдвэр гарахад тухайн шүүх хуралдааны ажлын хөлсийг төлөх ёстой болдог.
- Зээл олгогч шүүхийн шийдвэрээр өр барагдуулагч болон шүүхийн шийдвэр гүйцэтгэгчид хөрөнгө хураах бүрэн эрхийг хуулийн дагуу олгодог.
- Хөрөнгө хураах шийдвэрт шүүхийн ажлын хөлс мөнгөн дүнгээр бичигдсэн байдаг, мөн таны үндсэн өр нэмэгддэг.

8 ШИЙДВЭРИЙН ХҮЧ БА ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ

- Зээл олгогч (тодорхой) өр барагдуулагчыг олж тухайн өр барагдуулагч өрийг нэхэмжлэх талаар шүүхэд ханддаг. Шүүх түүнд шийдвэр гүйцэтгэх эрх олгосон шийдвэрийг гаргаж өгдөг. Шүүх өрийг хэрхэн төлүүлэх тухай шийдвэрлэхгүй - өр барагдуулагч өөрөө тогтоож хийдэг.
- Шийдвэр гарсан тухай баталгаат захиа зээл олгогч зээлдэгч нарт ирэхээс гадна ажлын газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн газрууд, өөрөө явагч тээврийн хэрэгсэлийн бүртгэлд явуулдаг. Шийдвэрийг авснаас хойш өөрийн эд хөрөнгийг худалдаж, бэлэглэж болохгүй.
- Шийдвэр гүйцэтгэгч хөрөнгийг битүүмжилсэн протокол бичдэг. Таны дансан дахь мөнгийг хүртэл битүүмжилж болно, шийдвэр гүйцэтгэгч танаас хураасан эд хөрөнгийг (байшин, машин гэх мэт) зарж борлуулах эрхтэй.

Анхаар, зээлдэгч буюу өртэй хүн өөр хэн нэгний байранд амьдарч байгаа тохиолдолд ч байрыг битүүмжилнэ.

- Шийдвэр гүйцэтгэгч өрийг барагдуулахын тулд таны дансны гүйлгээг битүүмжилдэг (obstavit účet): дансанд буй бүх бэлэн мөнгө, дансанд орж ирэх мөнгийг ч битүүмжилнэ. Тэрээр нийгмийн халамжийн мөнгөний тодорхой хэсгийг битүүмжилж авдаг. Таны орлогоос зөвхөн амжиргааны доод түвшний 2/3 тэнцэхүйц хэсгийг үлдээх ёстой.
- Өр барагдуулагч нар шүүхийн хувийн гэсэн үйл ажиллагаагаа явуулах арга нь хоорондоо ялгаатай бие даасан байгууллагууд байдаг. Өр барагдуулагч, шийдвэр гүйцэтгэгч нарт хуулийн дагуу үүргээ биелүүлэх эрхтэй байдаг.
- Танд зөвлөхөд нэгэнт эд хөрөнгө чинь битүүмжлэх үе шатанд байгаа бол шийдвэр гүйцэтгэгчтэй аль болох байдлийг эвтэйхэн шийдвэрлэх талаас ярилцаж, танд хүндээр тусаж болох хувилбарт хүрэхгүй байхыг хичээгээрэй.
- Өр барагдуулагч өөрийн ажилд зарцуулагдсан ажлын зардалаа танаас нэхэмжилж буй төлбөрт бодож оруулдаг.

9 БИТҮҮМЖЛЭХЭЭС ХАМГААЛЖ БОЛОХ УУ?

- Албадан эд хөрөнгө битүүмжлэх шийдвэрийн эсрэг давж заалдаж болох ба хэрвээ танд ямар нэгэн нотлох (жишээ нь: бүх өрийг төлсөн гэсэн) баримт байхгүй тохиолдолд эд хөрөнгийг битүүмжлэх шийдвэрт нөлөөлж чадахгүй юм.
- Шийдвэр гүйцэтгэгч шийдвэрт хамааралгүй, зүй бусаар эд хөрөнгө битүүмжилсэн үед гомдол гаргадаг (жишээ нь: захирамжинд тогтмол ирдэг цалинг данс битүүмжлэх тухай тогтоогүй байсан бол). Өр барагдуулагч байгууллагад эд хөрөнгийг битүүмжлэхээ түр зогсоох хүсэлт гаргаж болно.

- Шийдвэр гүйцэтгэгч өр барагдуулах ажлын зардлыг нөхөн төлөхгүй гэсэн эсэргүүцлээ захирамжийг гар дээрээ авснаас хойш 3 хоногийн дотор шийдвэр гүйцэтгэгч албанд мэдэгдэж болно. Таны эсэргүүцлийг шийдвэр гүйцэтгэгч биелүүлээгүй бол аль болох хурдан шүүхэд хандаарай: тэнд таны эсэргүүцэл гомдлыг 15 хоногийн дотор шийдэж өгнө.

Анхаар! Улсын чанартай өр нэхэмжлэлийг (татвар, нийгмийн болон эрүүл мэндийн даатгал) өр барагдуулагч шүүхийн захирамжгүйгээр гүйцэтгэх эрхтэй.

- Хэрвээ та гэрээ байгаагуулахдаа гэрээнд хавсаргагдсан шүүхийн нэмэлт тайлбартай (rozhodčí doložka / doložka vykonatelnosti) танилцаж гарын үсэг зурсан бол өр нэхэмжлэх үйл ажиллагаа шүүхийн шийдвэргүйгээр явагдана.

10 ТАНЫ АМЬДРАЛД ХЭРХЭН НӨЛӨӨЛӨХ ВЭ? ӨРНӨӨС ЯАЖ АНГИЖРАХ ВЭ?

- Өр барагдуулах албаны жагсаалтанд бүртгэгдэх ба дахин зээл авах үед танд асуудал үүсдэг.
- Та банкны зээлтэй мөн тухайн банканд данстай бол таны дансанд ордог мөнгөнөөс шүүх болон өр барагдуулах албаны шийдвэргүйгээр зээлдүүлэгч банк таны данснаас мөнгийг шилжүүлж болдог.
- Хэрвээ таны данс битүүмжлэгдсэн тохиолдолд дансанд орж ирэх цалин болоод бусад бүх мөнгө хураагддаг.
- Өрийг санхүүжүүлэх аргууд байдаг. Жишээлбэл: жижиг олон зээлээр нэгдсэн зээлийг нийлүүлж байгуулдаг (konsolidace). Энэ нь гэрээнд заасан хугацаандаа эргэн төлөлтийг хийж эхэлж чадвал байдлыг сайжруулах боломжтой. Konsolidace нэгтгэн байгуулсан зээл нь эргэн төлөлтийг хугацаанд төлөхөөс биш үндсэн өрийг багасгахгүй мөн төлөлтийн хугацаа уртсана. Та найдвартай банканд хандаарай.
- Хувь хүн эсвэл ямар нэгэн компани таны өмнөөс таны зээлийг шийдвэрлэх санал тавьдаг. Энэ нь нилээд эрсдэлтэй юм! Учир нь: та өөрөө зээл олгогчтойгоо ярилцаад тогтмол бага багаар төлөх хүсэлт гаргаж болох ажлыг таны оронд шийдвэрлэж мөн хэдийг яаж төлж байгаа нь таны хяналтнаас гадуур байдаг. Ийм ажил эрхэлдэг компаниуд голдуу баталгаатай биш байдаг!

11 УНАЛТ, ДАМПУУРАЛ

- Таны эд хөрөнгийн мөнгөн дүн таны өрний хэмжээнээс бага бол та уналтанд (úpadek) орж болно. Та шүүхэд өөрөө өөрийнхөө өмнөөс тодорхой нөхцөлтэйгөөр дампуурлын өргөдөл гаргавал дээр байж болно. Шүүх таны эд хөрөнгөд судалгаа явуулаад дампуурлыг зарладаг.

12 ӨРНИЙ БИТҮҮМЖЛЭЛЭЭС ЧӨЛӨӨЛӨХ (OSOVNÍ BANKROT)

- Уналтаас гарах тухайд.
- Гагцхүү зээлдэгч буюу өртэй хүн шүүхэд өрний битүүмжлэлээс чөлөөлөх өргөдөл гаргаж болно. Өргөдөлд шаардлагатай бичиг баримтыг (орлого, эд хөрөнгийн тодорхойлолт, гэр бүлийн гишүүний зөвшөөрөл) хавсаргах ёстой. Шүүх өрний битүүмжлэлээс чөлөөлөх төлөвлөгөө бодит байдалд нийцэж байгаа таны идэвхи санаачлага зэргийг харгалзаж үзнэ. Зээл олгогчид та дор хаяж нийт өрний 30 % төлсөн байх ёстой..
- Хэрвээ өр барагдуулагчийн хураагдсан эд хөрөнгө зарагдах тодорхой эсвэл ирэх 5 жилийн дотор өөрийн бүх орлогоор өрөө барагдуулах нь боломжтой бол шүүх, зээл олгогч зөвшөөрлөөр өрний битүүмжлэлээс чөлөөлж өрийг төлж дуусгах боломж олгосон шийдвэр гардаг. Шүүхийн шийдвэрээр таны орлогоос танд зөвхөн амжиргааны доод түвшиний мөнгө үлдээдэг.
- Хэрвээ өр барагдуулагч өрний битүүмжлэлээс чөлөөлөх боломж олгосон шийдвэрийн шаардлагыг биелүүлэхгүй бол битүүмжилсэн хөрөнгийг дуудлага худалдаанд оруулдаг.




Өр зээл, санхүүтэй холбоотой асуудлаар тусламж зөвлөгөөг Гадаад иргэдийг интегралчилах төвд ТББ (тодорхой мэдээллийг: www.cicpraha.org) хандаж болно. Эсвэл санхүүгийн асуудалд орсон хүмүүст зөвлөгөө өгөх байгууллагад хандаж болно:

Иргэдэд зөвлөгөө өгөх төв – <http://dluhy.obcanskeporadni.cz/>, Санхүүгийн хүнд нөхцөл дэх зөвлөгөө өгөх төв - www.financnitsen.cz, Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл: www.cicpraha.org/infooservis

Мэдээллийн агуулага хэвлэгдсэн хугацаандаа хүчинтэй, шаардлагатай өөрчлөлтийг эсэргүүцэх боломжгүй.



centrum
pro integraci
cizinců o. s.



ЗЭЭЛ БА ӨР – ТА ЮУ ХИЙХ ВЭ?

1 ӨР ГЭЖ ЮУ ВЭ? ХЭРХЭН ҮҮСДЭГ ВЭ?

- ▶ Өр гэдэг нь төлөх үүрэгтэй төлбөрийг төлөөгүйгээс эсвэл хугацаа хэтрүүлснээс үүссэн мөнгөн төлбөр. Өр нь дараах тохиолдолд үүсдэг:
 - Хэрэглэсэн үйлчилгээний төлбөрөө төлөөгүй (нийтийн тээвэр, байрны түрээс, газ, цахилгаан, утас, интернет)
 - Хуулинд заасан үүрэгт төлбөрийг тогтсон цаг хугацаанд нь төлөөгүй (нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал, татвар)
 - бэлэн мөнгө зээлсэн тохиолдолд
 - өөрийн данс, төлбөрийн картаа үлдэгдэлгүйгээр хэрэглэх (гэрээгээ анзаарна уу) гэрээнд заасан төлбөрийн картанд байх ёстой хамгийн бага хэмжээнээс илүүг хэрэглэвэл
 - хэн нэгэн банкнаас зээл авахад батлан даагч болох, ийм нөхцөлд тухайн зээл авсан хүн зээлээ төлөөгүй тохиолдолд банк танаас түүний зээлийг төлөхийг шаардана
- ▶ Хэн нэгний хийсэн өр зээл таны асуудал болж болно:
 - танайд амьдардаг эсвэл амьдарч байсан төрөл садан, ах дүүгийн өрний асуудлаар - өр барагдуулагч танайд очиж болно
 - эхнэр/нөхрийн хооронд – нэгнийхээ өмнөөс хариуцлага хүлээх үүрэгтэй эсвэл хамтдаа нэг гэрт амьдардаггүй ч бизнэс эрхлэхтэй холбоотой өр эхнэр нөхрийн аль нэгэнд ирж болно, тухайн өр „эхнэр нөхөр хоёрын эд хөрөнгө“ гэдэг юм шиг үздэг

Энэ танилцуулага гуравдагч орны иргэний интеграцад зориулан Европын сангаас дэмжлэг авсан төсөл юм.



MINISTERSTVO VNITRA
ČESKÉ REPUBLIKY

2

ӨР ҮҮСЭХИЙН ЭСРЭГ ТА ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?

- Та ямар ч мөнгө зээлгүй харин ямар нэг төлбөрийг хугацаа хэтрүүлж хийснээс өр үүсдэг. Байгууллага бүр төлбөрийг хугацаа хэтрүүлсэн тохиолдолд авах өөрийн дүрэмтэй байдаг. Ихэнхдээ торгууль (repale) гэсэн нэртэй тодорхой хувиар хүү тооцож авдаг.
- Заавал төлөх даатгалууд - нийгмийн, эрүүл мэндийн мөн татвар (татварын урьдчилгаа)-ыг цаг тухайд нь төлөх ёстой хэмжээгээр нь төлөөрэй.
- Орон байрны түрээс, түүнд багтах үйлчилгээнүүд (газ, цахилгаан эрчим хүч, утас, интернет) холбогдох бүх төлбөрүүдийг гэрээний дагуу төлөөрэй, хэрвээ танай гэр бүлийнхэнээс өөр хүн энэ бүхнийг хариуцдаг бол цаг хугацаандаа төлөгдөж байгаа эсэхийг шалгаж байгаарай.
- Хэрвээ ямар нэг төлбөрт үйлчилгээний гэрээг цуцлахыг хүсэж байгаа бол цуцлах хүсэлтээ цагт нь өгөхийн зэрэгцээ дахиад ямар хугацаанд тухайн үйлчилгээг төлөх ёстой вэ? гэдгээ олж мэдээрэй (цуцлах хугацаа).
- Нүүн шилжиж байгаа нөхцөлд өөрийн биеэр зохих газар нь очиж таны нэр дээр байгаа үйлчилгээг авах гэрээг цуцлаарай (газ, цахилгаан эрчим хүч түгээгүүрийн газар).
- Хаягын өөрчлөлтөө шаардлагатай үйлчилгээ авдаг байгууллагуудад мэдэгдэхийн зэрэгцээ тухайн байгууллагуудаас танд захиа байнга бэрхшээлгүй ирж байгаа эсэхийг шалгаарай.
- Үйлчилгээг хэрэглэх гэрээний дагуу төлбөрөө төлөөгүй тохиолдолд үйлчилгээг таслан зогсоож болно. **Анхаар!** *Үйлчилгээний тухай гэрээ нь хүчинтэй байгаа тохиолдолд сарын төлбөр бодогдсоор байдгыг санах хэрэгтэй.*
- Бизнес эрхлэгч гэр бүлийн хоёр гишүүний аль нэг нь тухайн үед хамтын өмч хөрөнгийнхөө хэмжээг багасгах (zúžení rozsahu spoločného jmění) өргөдлөө шүүхэд өгч болно.
- Үл хөдлөх хөрөнгийн хамтарсан зээлтэй гэр бүл салах тохиолдолд эсвэл салахаас өмнө зээлийн цаашидын байдал, түүний эргэн төлөлтийн талаар хэлэлцээр хийх ёстой. Хэрвээ та үүнийг шийдвэрлэхгүй бол та тусдаа амьдрах болсон ч зээлийн хүүг үргэлжлүүлэн төлөх болно. Энэ талаар зээл авсан банк танд зөвлөх ёстой!
- Нийтийн тээврээр үйлчлүүлэх үедээ үргэлж билет, тасалбараа авч байгаарай! Хэрвээ та хараар зорчиж байгаад торгуулсан бол торгуулиа аль болох хурдан төлж барагдуулаарай. Ямар нэг төлбөрийг төлөөгүйгээс болоод багахан хэмжээний төлбөр нэмэгдсээр та их хэмжээний төлөөсөнд унах аюултай!

3

БЭЛЭН МӨНГӨ ЗЭЭЛЭХ

- ▶ Та мөнгө зээлэх хэрэгтэй болсон уу?
 - Эхний үед та өөрийн төрөл садан, ах дүү, ойр дотны хэн нэгнээс хүү багатай эсвэл хүүгүй зээл хайгаад үзээрэй.
 - Үнэхээр танд хэн нэгэн байхгүй бол найдвартай банканд хандвал эрсдэл бага байж болно.
 - Танд хурдан зээл гаргаж өгнө, танаас таны орлогын тухай бичиг баримт, батлан даагч шаардахгүй гэсэн банк бус санхүүгийн байгууллагаас битгий зээлээрэй. Эдгээр нь эрсдэл ихтэй, өндөр хүүтэй, эргэн төлөгдөх явц нь хүндрэлтэй, ажлын зардал нь үнэтэй зэрэг байдаг.
 - Интернет, гудамж, сонин, телетекст зэрэгийн зарууд, утсаар тан руу ярих гэх зэрэг өөрсдөө танд санал болгож байгаа хүмүүсийн саналд хариу өгөхгүй, анзаарахгүй байсан нь илүү дээр.

Хэрвээ та бэлэн мөнгө зээлсэн бол зээлийн эргэн төлөлтийн гэрээнд заасны дагуу барагдуулах үүрэгтэй. Таны гол зорилго хангалттай, тогтмол орлоготой байх явдал. Гэнэт орлого хаагдсан шаардлагатай тохиолдолд өөртөө хэрэглэх нөөцтэй байгаарай.

4

ЛИЗИНГ БА БАРААГ ЗЭЭЛЭЭР ХУДАЛДАН АВАХ

- Зээл нь олон төрөл байдаг. Лизинг нь 5 000,- Кроноос дээш байдаг ба энэ нь хуулиар илүү батлагдсан байдаг.
- Бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг зээлээр авахдаа үнийн тодорхой хэсгийг эхэлж хийгээд үлдсэнийг тодорхой хугацааны дотор цувруулан төлөх нөхцөлтэй байдаг (ихэвчлэн долоо хоног, сараар).
- Суртчилгаандаа 7% хүүгээс эхлэнэ гэж байвал худалдан авагч голдуу үүнээс илүү хүү төлдөг.
- Лизингийн зээл авах гэрээ танд ойлгомжтой биш байвал та яаран гэрээ хийх гэсний хэрэггүй.
- Хэрвээ та лизингээ хурдан ахиу хэмжээгээр төлөх боломжгүй бол хүү өссөөр, хугацаа өнгөрөх тутам таны төлөх хэмжээ өссөөр байдаг.

Хуулийн дагуу танд лизингийн гэрээний нөхцөл таалагдахгүй бол 14 хоногийн дотор шалтгаан дурдахгүйгээр лизингийн зээлийг буцааж болдог. Гэрээг цуцлангуут лизинг тэр дороо хүчингүй болдог.

ЛИЗИНГ ӨӨР ХЭЛБЭРҮҮДТЭЙ БАЙЖ БОЛНО:

- ▶ **1. Төлбөрийн карт хүсээгүй**
Өөрөө төлбөрийн карт хүсээгүй ч (шуудангаар, дэлгүүрийн нээлтэн дээр тараагдсан) лизинг авж байж болно. Эсвэл утсаар танд урамшуулал болгож явуулсан картны тухай мэдэгдэж болно. Хэрвээ тухайн картыг мөнгөний машинд хийж идэвхжүүлээд түүгээр ямар нэг зүйл худалдан авангуут автоматаар гэрээний нөхцөлтэй танилцахгүйгээр зээлийн гэрээ байгуулагддаг.
- ▶ **2. Хямдралын үйл ажиллагаа, танилцуулах аялал, гэнэтийн худалдан авалт**
 - Хямдрал зарлалт, шинэ барааны танилцуулага, эсвэл ямар нэг бүтээгдэхүүнийг хямд үнээр, бонустай (бэлэг дагалдуулах, үнэгүй хоолонд орох) зарах гэх үйл ажиллагаанд та уригдсан байж болно.
 - Иймэрхүү үйл ажиллагаан дээр та барааг сайтар үзэж шалгах боломжгүйгээр шууд худалдан авах гэрээг байгуулдаг. Тэнд хийсэн гэрээ нь ихэнхдээ барааг лизингээр худалдан авах тухай гэрээ байдгаас гадна таныг хурдан шийдвэр гаргахыг шахдаг, ингэж зарж буй бараа танилцуулж байсан шигээ чанартай биш хэврэг байдаг.
 - Дээрх шиг эрсдэл дагуулсан худалдаа нь гэнэтийн худалдан авалт (борлуулагч нар цахилгаан эрчим хүч, газ, үүрэн телефон үйлчилгээний санал тавин шууд танай гэрт эсвэл гудамжинд тантай уулзан борлуулахыг оролддог). Энэ нь луйвар биш эсэхийг ямагт шалгаарай!
 - Энэ гэрээг 14 хонгийн дотор шалтгаан дурдахгүйгээр цуцалж барааг буцааж өгч болно.**
- ▶ **3. „Хожил“ гэдэг арга мэх**
Шуудангаар эсвэл утсаар таны хэзээ ч бүртгүүлж оролцоогүй сугалаа эсвэл тэмцээнд та хожсон тухай мэдээлдэг. Дараа нь жинхэнэ хожлоо авахын тулд та утсаар яриад, өөрийн биеэр ирж, ялангуяа та өөрийн хувийн мэдээллээ (дансны дугаар, ашиглаж болох бусад мэдээллэл!) өгч осолтой нөхцөлтэйгөөр бараа захиалах ёстой гэдэг. Энэ бол луйвар юм - иймэрхүү зүйлд хариу өгөхгүй байсан нь дээр!

5

ЗЭЭЛ, ЛИЗИНГИЙН ГЭРЭЭ

Зээл (růjсka) болон лизинг (úvěr) (цаашид зээл гэнэ) авах үед гэрээ байгуулдаг. Зээлийн нөхцөл ойлгомжтой, тодорхой байх шаардлагатай. Таны мэдэх ёстой зүйлүүд: нийт дүн, хүү түүнийг бодох арга, он сар өдөр, зээл олгогч эргэн төлөлтийг аль дансандаа авахыг хүсэж байгаа эсэх. Зээлд зөвхөн хүүгийн тухай ойлголтоос гадна зээлийг өгөх үеийн ажлийн хөлс, сар бүрийн дансны гүйлгээний шимтгэл, төлөх нөхцөлийн өөрчлөлтийн шимтгэл, хугацаанаас хожимдуулж төлсөний хүүгийн алдагдал, өөр гэрээний торгууль зэрэг багтана. Та байдлыг зассан үед, эргэн төлөлтийг хийж чадахгүй болоход мөн хугацаанаасаа өмнө төлж барагдуулахын давуу талууд зэргийг лавлаж мэдээрэй. Өндөр хэмжээтэй зээлийн гэрээ хийхэд албан ёсны баталгаа шаарддаг:

- зээл олгогч зээлдэгчээс хэн нэгэн өөр хүн түүнд баталгаа гаргахыг хүсдэг, жинхэнэ зээлдэгч зээлээ эргэн төлөх чадваргүй болсон тохиолдолд зээл олгогч баталгаа гаргагчаас мөнгийг шаардах эрхтэй,

- баталгаа нь таны эсвэл өөр хэн нэгний үл хөдлөх хөрөнгө байж болно,
- баталгаа гаргагч зээлийг батлан дааж зээлийн өрийг төлнө (чек) (směnka) - зарим банк бус санхүүгийн компаниуд гэрээнд зээлдэгч болон баталгаа гаргагчыг хамт он сар, зээлийн нийт дүнг бичээгүй цаасан дээр гарын үсэг зурахийг шаарддаг, дараа нь төлж чадахгүй болсон тохиолдолд таны эсрэг хэрэглэдэг. Баталгаа гаргагч зээлдэгч хоёр хамт гарын үсэг зурахгүй байхыг онцгой анхааруулж байна!

Зээлдэгч сайн дураар гэрээний үүргээ биелүүлэхгүй, хоёр тал тохиролцож чадахгүй бол эрх үүргийн тухай шүүх шийдвэр гаргана. Онцгой тохиолдолд гэрээний хэсэг болон хавсралтанд шүүгчийн нэмэлт тайлбар (rozhodčí doložka) хавсаргагдсан байж болно. Хэрвээ шүүгчийн нэмэлт тайлбар хавсаргагдсан гэрээтэй танилцаж гарын үсэг зурсан бол энэ нь нөхцөлийг зөвшөөрч байгаа гэсэн үг болно. Эргэн төлөлтийн талаарх маргааныг шүүгч (rozhodce)-ийн нэмэлт тайлбараар тохиролцсон гэж үзээд шүүхэд хандахгүй. Зээл олгогч шүүгчийг тодорхойлно. Шүүгч зээл олгогчын үр дүндийн талаар хэлэлцэнэ, мөн та түүний шийдвэрийн эсрэг давж заалдах боломжгүй.

6

ТА ЗЭЭЛЭЭ ТӨЛӨХГҮЙ ТОХИОЛДОЛД ЮУ БОЛОХ ВЭ?

- Эргэн төлөлтийг хэлэлцсэн хугацаанаас хэд хоногоор хоцорч төлвөл алданги хүү тооцоход хүргэнэ.
- Хэрвээ та өрөнд орвол нэн түрүүнд танд аюултай байж болох – байрны түрээс, цахилгаан эрчим хүч, хамгийн бага гэрээний нөхцөлтэй зээл, хүүхдийн тэтгэвэр зэргийг цувруулж төлөх хэрэгтэй.
- Анхаар!** *Хүүхдийн тэтгэврийг төлөхгүй байх нь эрүүгийн харууцлага тооцож шоронд орох хүртлэх шалтгаан болдог.*
- Хэрвээ та гэрээний дагуу цувруулж төлж чадахгүй бол цаг алдалгүй тухайн гэрээ байгуулсан байгууллагад мэдэгдээрэй. Цувруулж, багасгасан хэмжээгээр төлөх хүсэлт гаргаж болно. Та өөрийнхөө төлж чадах хэмжээнд гаргасан санал байвал зохино. Зээл олгогч таны төлөлтийн талаарх багасгасан саналыг зөвшөөрөх хэмжээнд байх ёстой. Гэвч түүнд таны өргөдлийг зөвшөөрөхгүй байх эрх бий. Дахин сар бүр цувруулж төлөх өргөдлөө өгөөд үзээрэй ямартай ч битгий орхиорой. Сүүлийн хугацаанд чадах чинээгээрээ бага хэмжээний мөнгийг данс руугаа тогтмол хийгээрэй. Шүүхээр шийдвэрлүүлэх хэмжээнд хүрвэл таны төлөх гэсэн оролдлого маш чухал нөлөөтэй.
- Эргэн төлөлтийн хугацааг сунгах тухайд та богино хугацаанд төлөж барагдуулах хүсэлт гаргаж болно. Зээл олгогч зөвшөөрөх албагүй.
- Зээлдүүлгчтэй ямагт бичгээр харилцаж байгаарай! Хэрвээ түүнтэй зөвхөн утсаар ярьвал тодорхой хугацааны дараа утсаар тохиролцсон хэлэлцээрийг үгүйсгэж болно. Биеэр уулзсан уулзалтаас бичгийн хариуг авч явж байгаарай- жишээ нь: эргэн төлөлтийн өөрчлөлтийн тухай тохиролцоо.
- Өр барагдуулалтын эхний шатанд зээлийн хүү, шимтгэл, дараа нь үндсэн өр төлөгдөх шатандаа ордог! Тийм болохоор дэндүү бага хэмжээний мөнгөний алданги, шимтгэл өссөөр үндсэн өр багасалгүй магадгүй өссөөр байж болно!
- Таны цалингаас тухайн байгууллага өөрөө шаардлагатай мөнгийг урьдчилан авч байгаа гэж битгий таамаглан бодоорой. (Жишээ нь: нэгдүгээр улиралд газ-ын газар танд илүү төлбөр байгаа боловч хоёрдугаар улиралд дутсан тохиолдолд танд газ-ын газраас төлбөрөө хийхийг сануулна, нийтийн тээврийн газрын хоёр удаагын торгууль хоёр өөр тусдаа гомдол болж ирнэ.)

7

НЭХЭМЖЛЭЛ

Ямар нэг шалтгааны улмаас зээлээ төлөөгүй хугацаа хэтрүүлсэн мөн зээл олгогчтой дараагийн үе шатны талаар тохиролцоогүй тохиолдолд таныг дараах зүйл хүлээнэ:

- Зээл олгогч танд үе үе нэг болон түүнээс дээш санамж бичиг явуулна. Зарим хувийн байгууллагууд анхааруулага бичиг явуулахгүйгээр шууд өмгөөллийн товчоо эсвэл өр барагдуулах албанд ханддаг. Өмгөөллийн товчоо, өр барагдуулах алба тантай захиагаар эсвэл биеэр холбогдохыг хичээж, өрийг төлөхийг шаарддаг. Энэ үед байдлыг тохиролцож болох талтай, гэвч үндсэн өр түүний хүү, хугацаа хэтрэлтийн хүү, товчооны ажлын хөлс зэргийг нэмж боддог.